



ДУНДГОВЬ АЙМГИЙН
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 1700

Тавин

Хорио цээрийн дэглэм
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “А” заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйл, Засгийн газрын 2008 оны 305 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 4-р багийн малчин Ш.Цэрэнбат /Холбоо/, Т.Адъяабазар /Дураал/, 3.Ариунсанаат /Баяндай/ нарын үхэрт малын халдварт “Шүлхий” өвчний сэжиг илэрсэн тул 2018 оны 02 сарын 18-ны өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаатай хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2. Малын гоц халдварт өвчин гарсантай холбогдуулан нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, хүн малын хөдөлгөөнд хорио тогтоож, малын гаралтай түүхий эд, мах махан бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж, тээвэрлэхийг хориглосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж тухай бүр мэдээллээр хангаж ажиллахыг МЭҮТасаг, багийн засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТХӨЛӨГ